



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/44

Баянгол

Г Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "б", 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 26 дугаар зүйлийн 26.1.2 дахь заалтыг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Сумын гамшгаас хамгаалах удирдлагын байрыг сумын Засаг даргын Тамгын газрын танхимаар тогтоож, ажиллах жижүүрийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Тус сумд гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулж байгаатай холбогдуулан 2017 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

3. Дайчилгааны үед шаардагдах хүн хүч, машин техник, шатах тослох материал, хүнсний нөөцийг бүрдүүлж ажиллахыг хангалт хариуцсан туслах Х.Төртулгад үүрэг болгосугай.

4. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед архи согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байхыг "Тахийн Шарга" ХХК, "Дүүрэн Шарга" ХХК, "Шалзад баахан Шарга" ХХК-ийн захирал нарт, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч Т.Гэндэнсүрэнд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  М.ТУНГАЛАГТАМИР





**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

20 17 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/45

Баянгол

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйл, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 1 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

- 1. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг орон нутагт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

- Ажлын хэсгийн ахлагч Р.Оюунчмэг /ЗДТГ-ын дарга/
- Нарийн бичгийн дарга Г.Өлзийсайхан /ХХҮГ-ын мэргэжилтэн/
- Гишүүд:Х. Даваацэрэн /МЭҮТ-ийн дарга/
- Г.Ган-Очир /Баянгол багийн засаг дарга/
- Ж.Эрдэнэпүрэв /Хамтын хүч багийн засаг дарга/
- Ц.Даваадорж /Сондуулт багийн засаг дарга/
- Б.Гантулга /Улаантуг багийн засаг дарга/

- 2. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг чанартай зохион байгуулж мэдээ тайланг хугацаанд нь хүргүүлэн ажиллахыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга /Г.Өлзийсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  М.ТУНГАЛАГТАМИР

